

# New transfer pricing rules in Mongolia

The tax reform effective from 1 January 2020 introduced new transfer pricing (“TP”) rules to align with the international requirements. The first reporting period is 2020 with a reporting deadline in February 2021. This tax alert summarises main highlights of these updates.

## Contacts

### Michael Ahern

Partner, Tax and Legal Services  
Leader  
michael.ahern@pwc.com

### Tsendmaa Choijamts

Executive Director, Tax and Legal  
Services  
tsendmaa.choijamts@pwc.com

### Maryna Tarnavska

Senior Manager, Transfer Pricing  
Services Leader  
tarnavska.maryna@pwc.com

### Azzaya Lkhachin

Manager, Transfer Pricing  
Services  
azzaya.lkhachin@pwc.com

### PwC Tax TMZ LLC

Central Tower 6th floor  
Suite 603, Ulaanbaatar  
14200, Mongolia  
Tel : + 976 70009089  
Fax : +976 11 322068  
[www.pwc.com/mn](http://www.pwc.com/mn)

## General TP principle introduced in the law

If conditions of the transactions between related parties (“controlled transactions”) are different from conditions of transactions between unrelated parties (“independent transactions”), and the tax base was reduced as a result, the tax base shall be increased by the differences of such reduced amount and relevant reassessed tax shall be levied.

## TP legislation

- The General Taxation Law, dated 22 March 2019, provides general TP rules including the TP principles, requirements for TP reporting, use of TP methods and TP adjustments.
- The Corporate Income Tax Law, dated 22 March 2019, along with tax rules applied in related party transactions, provides the detailed guideline on a country-by-country reporting.
- “The Regulation on TP adjustment and selection of TP methods” approved by the Ordinance # 308 of the Minister of Finance and dated 31 December 2019 provides the detailed guidance on a comparability analysis, TP adjustment, application of TP methods.

The tax authorities can also use the Transfer Pricing Guidelines for Multinational Enterprises and Tax Administrations by Organization for Economic Cooperation and Development (the “OECD TP Guidelines”) for TP adjustment and other purposes, if there are no definite rules in the domestic TP legislation, provided it does not contradict the latter.

## Scope of TP legislation

TP rules apply to all types of transactions conducted between related parties. The legislation does not provide any monetary thresholds for related party transactions to be in the scope of the TP rules. The Mongolian TP rules apply to both cross-border and domestic related party transactions.



**pwc**

This Alert is produced by PwC Tax TMZ LLC. The material contained in this alert is provided for general information purposes only and does not contain a comprehensive analysis of each item described. Before taking (or not taking) any action, readers should seek professional advice specific to their situation. No liability is accepted for acts or omissions taken in reliance upon the contents of this alert.

© 2020 PricewaterhouseCoopers Tax TMZ LLC.

All rights reserved. In this document, “PwC” refers to PricewaterhouseCoopers Tax TMZ LLC, which is a member firm of PricewaterhouseCoopers International Limited, each member firm of which is a separate legal entity.

TP concept	Description
<b>Arm's length principle</b>	<p>The arm's length principle, which is the international standard that OECD member countries have agreed, should be used for determining transfer prices for tax purposes. Under this principle, the conditions made or imposed between two related parties in their commercial or financial relations should not differ from those that would be made between independent parties engaging in similar transactions under similar circumstances.</p> <p>The Mongolian TP legislation includes a concept of the arm's length principle and foregoing ones are reflected in the newly adopted TP legislation:</p> <ul style="list-style-type: none"> <li>• The conditions applied in controlled transactions shall be compared with the conditions of the independent transactions;</li> <li>• When there is a difference, and as a result, the tax base has been reduced, the accurate TP adjustment should be made to eliminate the effect of such difference, and the tax base shall be increased and taxed accordingly.</li> </ul>
<b>Related party definition</b>	<p>The new definition of related parties was introduced, which is referable in all tax relations. <b>Related parties are generally defined</b> as the persons who have the ability to influence each other on the terms or economic outcome of a transaction by a way of direct or indirect participation, by a person in the other, or the same person in two or more persons' assets, control or managerial activities, and include:</p> <ol style="list-style-type: none"> <li>1) <i>taxpayer's parents, siblings, children, grandparents, grandchildren, spouse, partner and their parents and siblings;</i></li> <li>2) <i>members of the same group ("group" is defined as the entities related for ownership or management and those included in the consolidated financial statement prepared for the financial reporting purposes or in the consolidated financial report prepared when any of the entities listed in a stock exchange market);</i></li> <li>3) <i>a person, who directly or indirectly owns 20% or more of the shares, contribution or voting rights;</i></li> <li>4) <i>direct or indirect beneficiary of at least 20% or more of the profits or liquidation proceeds;</i></li> <li>5) <i>entities which are controlled by a third same person, who directly or indirectly, owns 20% or more of the shares, contribution or voting rights in such entities;</i></li> <li>6) <i>entities which are controlled by third same person, who is a beneficiary of at least 20% or more of the profits or liquidation proceeds in such entities;</i></li> <li>7) <i>entities stipulated in items (3), (4), (5) and (6) above, if owned directly or indirectly by the persons referred to in (1) above;</i></li> <li>8) <i>persons referred to in (1) above, their appointer, their assignee or their authorized representative;</i></li> <li>9) <i>persons referred to in (1) above, and a branch or a permanent establishment and its related parties;</i></li> <li>10) <i>persons who established relationship to reduce taxable income or increase loss of a resident taxpayer of Mongolia;</i></li> <li>11) <i>other persons similar to those referred to the general definition.</i></li> </ol>
<b>Comparability analysis</b>	<p>Application of the arm's length principle is generally based upon a comparison of the economically relevant characteristics of a controlled transaction with the economically relevant characteristics of independent transactions.</p> <p>In order for a controlled transaction to satisfy the arm's length principle, it must be sufficiently comparable to an independent transaction.</p> <p>If material differences exist between the controlled and independent transactions, then reasonable adjustments must be made to eliminate the effect of such differences on the price or result (i.e. margin) of such transactions.</p>

TP concept	Description
<b>Comparability analysis (cont'd)</b>	<p>The TP legislation describes the steps applied in the comparability analysis, including:</p> <ul style="list-style-type: none"> <li>• requirements on a covered tax period;</li> <li>• broad-based analysis of the taxpayer's circumstances;</li> <li>• analysis of comparability factors (such as the contractual terms, the functions performed, assets used, risks assumed by the parties to the transaction, characteristics of the goods/services transferred between the parties etc.);</li> <li>• determination of available information sources;</li> <li>• selection of the TP method/s;</li> <li>• determining or making a comparability adjustment;</li> <li>• determination of the arm's length remuneration.</li> </ul>
<b>TP methods</b>	<p>In establishing whether the conditions imposed in the commercial or financial relations between related parties are consistent with the arm's length principle, the OECD TP Guidelines describe TP methods, such as "traditional transaction methods" and "transactional profit methods".</p> <p>Traditional transaction methods are:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Comparable uncontrolled price ("CUP") method;</li> <li>• Resale price method ("RPM");</li> <li>• Cost plus method ("CPM").</li> </ul> <p>Transactional profit methods are:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Transactional net margin method ("TNMM");</li> <li>• Transactional profit split method ("TPSM").</li> </ul> <p>No one method is preferred over another, and it is necessary to select the most appropriate method for a given case. During the TP analysis, the most appropriate method is selected based on the quality and availability of information on the comparable, degree of comparability between the transactions.</p> <p>In line with the OECD's TP Guidelines, the Mongolian TP legislation also refers to five methods described above. The taxpayers are entitled to use the methods separately or in combination. For the purpose of applying the chosen TP method to a particular transaction, the taxpayer should compare the advantages and disadvantages of each method.</p> <p>The law allows to use the 6th method that should be in line with the general TP principle. This 6th method may include an asset valuation method, a market based method, a cost based method, or income based method. For mining commodities, if there is no comparable product to use CUP method, then announced price source can be used, subject to the Government's guidelines.</p>
<b>Sources of information</b>	<p>As outlined in the OECD TP Guidelines, a common source of information used in identifying potential comparable transactions could be:</p> <ul style="list-style-type: none"> <li>• publicly available information;</li> <li>• commercial databases;</li> <li>• information from internal sources (i.e. internal comparable transactions, if available);</li> <li>• and other.</li> </ul> <p>The Mongolian TP legislation states that if a taxpayer made a comparability adjustment, then a source of information along with supporting documents must be attached to the TP report.</p>

TP concept	Description																							
<p><b>TP adjustment</b></p>	<p>If the actual facts of the transactions differ from the terms stated in the formal contracts concluded between related parties, then the tax authorities have a right to make a TP adjustment based on results of the TP analysis.</p> <p>In addition, if taxpayers did not prepare TP reports, or reduced a tax base, the tax authorities will make a primary TP adjustment and reassess a tax. For corporate income tax or personal income tax purposes, differences arising as a result of the primary adjustment will be treated as a dividend and taxed accordingly as a secondary TP adjustment.</p> <p>If a taxpayer makes a comparability adjustment, such adjustment shall be supported by a source of information and other documents.</p> <p>Double taxation arising as a result of TP adjustments will be resolved as follows:</p> <ul style="list-style-type: none"> <li>• If a double taxation is due to a TP adjustment made by the Mongolian or foreign tax administration, then tax authority will follow mutual agreement procedure (“MAP”) in accordance with international tax agreements and MAP regulation.;</li> <li>• If a double taxation of a Mongolian tax resident is due to a TP adjustment made by the tax authority in accordance with the Mongolian law, then the tax authority can eliminate such double taxation through a corresponding adjustment.</li> <li>• In all other cases, the tax authority will not make an adjustment to reduce a taxable base.</li> </ul>																							
<p><b>TP reporting</b></p>	<p>Qualifying taxpayers should prepare and submit to the tax authorities the following <b>TP reports</b>:</p> <table border="1" data-bbox="341 1088 1524 1671"> <thead> <tr> <th data-bbox="341 1088 400 1167">N</th> <th data-bbox="400 1088 580 1167">Name of TP report</th> <th data-bbox="580 1088 839 1167">Content</th> <th data-bbox="839 1088 1270 1167">Who should file?</th> <th data-bbox="1270 1088 1524 1167">When should submit?</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="341 1167 400 1272">1</td> <td data-bbox="400 1167 580 1272">Annual transactional TP report</td> <td data-bbox="580 1167 839 1272">Information about all related party transactions</td> <td data-bbox="839 1167 1270 1272">All taxpayers who have the related party transactions</td> <td data-bbox="1270 1167 1524 1272">10<sup>th</sup> of February following the year end</td> </tr> <tr> <td data-bbox="341 1272 400 1377">2</td> <td data-bbox="400 1272 580 1377">Local File</td> <td data-bbox="580 1272 839 1377">Detailed information about activities in Mongolia</td> <td data-bbox="839 1272 1270 1377" rowspan="2">Companies or group with annual turnover of more than MNT 6 billion (approx. USD 2 million) for a preceding tax year; or foreign invested companies irrespective of their size</td> <td data-bbox="1270 1272 1524 1377" rowspan="2">10<sup>th</sup> of February following the year end</td> </tr> <tr> <td data-bbox="341 1377 400 1482">3</td> <td data-bbox="400 1377 580 1482">Master File</td> <td data-bbox="580 1377 839 1482">Overview of the group business and operations</td> </tr> <tr> <td data-bbox="341 1482 400 1671">4</td> <td data-bbox="400 1482 580 1671">Country-by-country report (CbCR)</td> <td data-bbox="580 1482 839 1671">Aggregate financial and tax information per jurisdiction</td> <td data-bbox="839 1482 1270 1671">A group parent entity which resides in Mongolia or other assigned entities of the group, who's the consolidated sales revenue is more than MNT 1.7 trillion (approx. USD 600 million).</td> <td data-bbox="1270 1482 1524 1671">Within the 12 month period after the last day of the group financial year</td> </tr> </tbody> </table>	N	Name of TP report	Content	Who should file?	When should submit?	1	Annual transactional TP report	Information about all related party transactions	All taxpayers who have the related party transactions	10 <sup>th</sup> of February following the year end	2	Local File	Detailed information about activities in Mongolia	Companies or group with annual turnover of more than MNT 6 billion (approx. USD 2 million) for a preceding tax year; or foreign invested companies irrespective of their size	10 <sup>th</sup> of February following the year end	3	Master File	Overview of the group business and operations	4	Country-by-country report (CbCR)	Aggregate financial and tax information per jurisdiction	A group parent entity which resides in Mongolia or other assigned entities of the group, who's the consolidated sales revenue is more than MNT 1.7 trillion (approx. USD 600 million).	Within the 12 month period after the last day of the group financial year
N	Name of TP report	Content	Who should file?	When should submit?																				
1	Annual transactional TP report	Information about all related party transactions	All taxpayers who have the related party transactions	10 <sup>th</sup> of February following the year end																				
2	Local File	Detailed information about activities in Mongolia	Companies or group with annual turnover of more than MNT 6 billion (approx. USD 2 million) for a preceding tax year; or foreign invested companies irrespective of their size	10 <sup>th</sup> of February following the year end																				
3	Master File	Overview of the group business and operations																						
4	Country-by-country report (CbCR)	Aggregate financial and tax information per jurisdiction	A group parent entity which resides in Mongolia or other assigned entities of the group, who's the consolidated sales revenue is more than MNT 1.7 trillion (approx. USD 600 million).	Within the 12 month period after the last day of the group financial year																				
<p><b>Penalty on non-submission of TP reports</b></p>	<p>In case of non-submission of TP reports, the following penalties will apply:</p> <ul style="list-style-type: none"> <li>• For an <b>annual transactional TP report</b>, a penalty is 2% from the total amount of related party transactions;</li> <li>• For a <b>local file and master file</b>, a penalty is 3% from the total amount of related party transactions;</li> <li>• For a <b>CbCR</b>, a penalty is 4% from the total amount of related party transactions.</li> </ul>																							

TP concept	Description
Other matters	<ul style="list-style-type: none"> <li>• The newly introduced TP rules are expected to be supplemented by the detailed guidance on the TP reporting.</li> <li>• There are no rules introduced with respect to advance pricing arrangements.</li> <li>• A general statute of limitation for tax purposes in Mongolia is 4 years. For TP adjustment purposes, when the tax authority requests the information from the foreign tax administration, the period between the date of request and the date of response from the foreign tax authority will be frozen.</li> <li>• Transactions with related parties from non-cooperative tax jurisdictions may trigger tax reassessment by the tax authority. The tax authority will announce in its official webpage the list of non-cooperative tax jurisdictions by the 10th of January each year.</li> </ul>

## How PwC can help you

### Compliance:

- Prepare / localize / update transfer pricing documentation for all types of transactions
- Prepare benchmarking studies for prices, profitability margins, interest rates, royalty
- Prepare annual transactional TP report, Local File, Master File and CbCR

### Day-to-day support:

- Diagnostics of transfer pricing risks
- Develop transfer pricing policies and procedures, train in-house specialists
- Assist with transfer pricing matters ad-hoc

### Planning and transformation:

- Structure your business in a tax efficient way
- Align transfer pricing with your business model
- Attribute profit to a permanent establishment appropriately

### Position defense and dispute resolution:

- Develop defense strategy and argumentation
- Support during tax audits and coordinate positions with tax authorities
- Support during tax appeals
- Assist with mutual agreement procedures



## Монгол Улсын Үнэ шилжилтийн шинэ дүрмүүд

2020 оны 1-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн татварын шинэчлэлийн хүрээнд олон улсын стандарт жишигт нийцсэн үнэ шилжилт (“ҮШ”)-ийн шинэ дүрмүүдийг нэвтрүүлсэн. Шинэчилсэн зохицуулалтын хүрээнд 2020 оны ҮШ-ийн тайланг 2021 оны 2-р сард багтаан тайлагнана. Энэ татварын мэдээлэлд үүнтэй холбоотой гарсан өөрчлөлтүүдийг танилцуулна.

### Холбогдох хаяг:

#### Майкл Ахэрн

Партнер, Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
michael.ahern@pwc.com

#### Чойжамцын Цэндмаа

Гүйцэтгэх захирал, Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ  
tsendmaa.choijamts@pwc.com

#### Марина Тарнавская

Ахлах Менежер, Үнэ шилжилтийн үйлчилгээ хариуцсан удирдагч  
tarnavska.maryna@pwc.com

#### Лхачингийн Аззаяа

Менежер, Үнэ шилжилтийн үйлчилгээ  
azzaya.lkhachin@pwc.com

#### ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК

Сентрал Тауэр, 6 давхар  
603 тоот, Улаанбаатар  
14200, Монгол улс  
Утас : + 976 70009089  
Факс : +976 11 322068  
[www.pwc.com/mn](http://www.pwc.com/mn)

### Хуульд тусгагдсан ҮШ-ийн ерөнхий зарчим

Харилцан хамааралтай этгээдүүдийн хоорондын ажил гүйлгээ (“хяналтад байгаа ажил гүйлгээ”) –ний нөхцөл нь харилцан хамааралгүй этгээдүүдийн хоорондын ажил гүйлгээ (“бие даасан ажил гүйлгээ”) -ний нөхцөлөөс ялгаатай ба үүний үр дүнд татварын суурь буурсан бол тухайн буурсан дүнгээр татварын суурийг өсгөж, татварыг нөхөн ногдуулна.

### ҮШ-ийн хууль тогтоомж

- 2019 оны 3 сарын 22-ний өдөр батлагдсан Татварын Ерөнхий хуульд ҮШ-ийн ерөнхий зарчим ба тайлагналын шаардлагууд, ҮШ-ийн тохируулга, ҮШ-ийн аргуудын хэрэглээ зэрэг зохицуулалтуудыг тусгасан байна.
- 2019 оны 3 сарын 22-ний өдөр батлагдсан Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын хуульд харилцан хамааралтай этгээдүүдийн хоорондын ажил гүйлгээнд хэрэглэх татварын дүрмүүдээс гадна Улс бүрээр тайлангийн нарийвчилсан зааврыг тусгасан байна.
- Сангийн сайдын 2019 оны 12 сарын 31-ний өдрийн 308 дугаар тушаалаар баталсан “ҮШ-ийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох, хэрэглэх журам” -д харьцуулагдах байдлын шинжилгээ, ҮШ-ийн тохируулга, ҮШ-ийн аргуудын хэрэглээний талаар дэлгэрэнгүй зааварчилгааг тусгасан байна.

Татварын алба нь дотоодын хууль тогтоомжид тодорхой заагаагүй, дотоодын хууль тогтоомжтой зөрчилдөөгүй тохиолдолд ҮШ-ийн тохируулга хийх болон бусад асуудлаар Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллагаас эрхлэн гаргасан Үндэстэн Дамнасан Корпораци болон Татварын Албад зориулсан Үнэ Шилжилтийн Удирдамж (“ЭЗХАХБ-ын ҮШ-ийн Удирдамж”) – ийг ашиглаж болохоор хуульд заасан байна.

### ҮШ-ийн хууль тогтоомжийн цар хүрээ

Хууль тогтоомжид ҮШ-ийн зохицуулалтаас чөлөөлөгдөх ажил гүйлгээний босго дүнг тодорхойлоогүй тул шинэчилсэн ҮШ-ийн дүрэм нь харилцан хамааралтай этгээдүүдийн хооронд гарсан бүх төрлийн ажил гүйлгээнд үйлчилнэ. Түүнчлэн, Монгол улсын ҮШ-ийн зохицуулалт нь харилцан хамааралтай этгээдүүдийн хооронд хийгдсэн гадаад болон дотоод бүх төрлийн ажил гүйлгээнд үйлчилнэ.



**pwc**

Энэхүү мэдээллийг PwC Такс ТМЗ ХХК-аас бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцаагүй болно.

© 2020 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсвотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК-г илэрхийлнэ.

ҮШ-ийн үзэл баримтлал	Тайлбар
<p><b>Сунгасан гарын зарчим</b></p>	<p>Сунгасан гарын зарчим нь татварын зорилгоор ажил гүйлгээний шилжүүлэх үнийг тодорхойлоход ашиглах зорилгоор ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын хүлээн зөвшөөрсөн олон улсын стандарт юм. Уг зарчмын дагуу харилцан хамааралтай этгээдүүдийн хоорондын арилжааны болон санхүүгийн харилцаанд тавигдсан нөхцөлүүд нь бие даасан этгээдүүдийн хоорондын ижил нөхцөл байдалд хийгдэж буй ижил төрлийн ажил гүйлгээнд тавигдсан нөхцөлүүдээс ялгаатай байх ёсгүй гэж үздэг.</p> <p>Монгол улсын ҮШ-ийн хууль тогтоомж нь сунгасан гарын зарчмын ойлголтыг агуулсан бөгөөд хууль тогтоомжид дараах зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хяналтад байгаа ажил гүйлгээний нөхцлүүдийг бие даасан ажил гүйлгээний нөхцлүүдтэй харьцуулна;</li> <li>• Харьцуулалтын үр дүнд зөрүүтэй байх буюу татварын суурь буурсан тохиолдолд энэхүү зөрүүний нөлөөллийг арилгахын тулд нарийвчлан тооцоолсон ҮШ-ийн тохируулгыг хийж улмаар татварын суурийг өсгөж, татварыг нөхөн ногдуулна.</li> </ul>
<p><b>Харилцан хамааралтай этгээдийн тодорхойлолт</b></p>	<p>Харилцан хамааралтай этгээдийн тодорхойлолт шинэчлэгдсэн ба энэ нь бүх төрлийн татварын харилцаанд ашиглагдана. <b>Харилцан хамааралтай этгээдийг ерөнхийлөн тодорхойлохдоо</b> нэг этгээд нөгөө этгээдийн, эсхүл уг этгээдүүд нь хоёр болон түүнээс дээш хуулийн этгээдийн хөрөнгө, хяналт, удирдлагын үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар оролцох замаар хоорондоо хийх ажил гүйлгээний нөхцөл, эдийн засгийн үр дүнд нөлөөлөх боломжтой этгээдүүд байх ба дараах этгээдүүдийг хоорондоо харилцан хамааралтай гэж үзнэ:</p> <ol style="list-style-type: none"> <li>1) <i>Татвар төлөгчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, өвөг эцэг, эмэг эх, ач, зээ болон эхнэр (нөхөр), хамтран амьдрагч, тэдгээрийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү;</i></li> <li>2) <i>нэг группт хамаарах этгээд (“групп” гэж санхүүгийн тайлагналын зорилгоор нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг, эсхүл аль нэг аж ахуйн нэгжийн хувьцаа хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдах үед нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргадаг, өмчлөл болон удирдлагын хувьд хамааралтай аж ахуйн нэгжүүдийг хэлнэ);</i></li> <li>3) <i>хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийг 20% ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг этгээд;</i></li> <li>4) <i>ашиг, эсхүл татан буугдсаны дараах үлдэгдэл хөрөнгөөс 20% ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар хүртэх эрхтэй этгээд;</i></li> <li>5) <i>хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20% ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг 3-дагч этгээдэд хянагддаг этгээдүүд;</i></li> <li>6) <i>ашиг, эсхүл татан буугдсаны дараах үлдэгдэл хөрөнгөөс 20% ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар хүртэх 3-дагч этгээдэд хянагддаг этгээдүүд;</i></li> <li>7) <i>(1)-д заасан этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшдэг (3), (4), (5), (6)-д заасан этгээдүүд;</i></li> <li>8) <i>(1)-д заасан этгээд, тэдгээрийг томиолох эрхтэй этгээд, тэдгээрийн эрх, үүргийг шилжүүлэн хүлээн авсан этгээд, эсхүл тэдгээрийг төлөөлөхөөр сонгогдсон этгээд;</i></li> <li>9) <i>(1)-д заасан этгээд болон харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжийн салбар, төлөөний газар;</i></li> <li>10) <i>Монгол улсад оршин суугч татвар төлөгчийн татвар ногдуулах орлогыг бууруулах, алдагдлыг өсгөх үндсэн зорилгоор харилцаа тогтоосон этгээд;</i></li> <li>11) <i>Ерөнхий тодорхойлолтод нийцэх бусад этгээдүүд.</i></li> </ol>
<p><b>Харьцуулагдах байдлын шинжилгээ</b></p>	<p>Сунгасан гарын зарчмын хэрэгжилт нь ерөнхийдөө хяналтад байгаа ажил гүйлгээний эдийн засгийн шинж чанарууд ба бие даасан ажил гүйлгээний эдийн засгийн шинж чанаруудын харьцуулалтад суурилдаг.</p> <p>Хяналтад байгаа ажил гүйлгээ нь сунгасан гарын зарчимд нийцэхийн тулд юуны өмнө бие даасан ажил гүйлгээтэй хангалттай харьцуулагдахуйц байна.</p> <p>Хэрэв хяналтад байгаа ажил гүйлгээ болон бие даасан ажил гүйлгээний хооронд материаллаг зөрүү байгаа бол уг зөрүүний нөлөөллийг арилгахын тулд уг ажил гүйлгээнүүдийн үнэ эсхүл үр дүнд (жишээ нь ашгийн хувь) зохих тохируулгыг хийнэ.</p>



ҮШ-ийн үзэл баримтлал	Тайлбар
<p><b>Харьцуулагдах байдлын шинжилгээ (үргэлжлэл)</b></p>	<p>ҮШ-ийн хууль тогтоомжид харьцуулагдах байдлын шинжилгээ хийхэд анхаарах дараах зохицуулалтуудыг тусгасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хамаарах татварын жилд тавигдах шаардлага;</li> <li>• Татвар төлөгчийн нөхцөл байдалд өргөн хүрээний шинжилгээ хийх;</li> <li>• Харьцуулагдах хүчин зүйлст шинжилгээ хийх (гэрээний нөхцөл, гүйцэтгэж буй чиг үүрэг, ашиглаж буй хөрөнгө, шилжүүлсэн бараа, үйлчилгээний шинж чанарууд гэх мэт);</li> <li>• Боломжит мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох;</li> <li>• Үнэ шилжилтийн аргыг сонгох;</li> <li>• Харьцуулалтын тохируулга хийх эсэхийг тодорхойлох, шаардлагатай бол тохируулга хийх;</li> <li>• Сунгасан гарын зарчимд нийцсэн бодит үнийг тодорхойлох.</li> </ul>
<p><b>ҮШ-ийн аргууд</b></p>	<p>Харилцан хамааралтай этгээдүүдийн хоорондын арилжааны болон санхүүгийн харилцаанд тусгасан нөхцлүүд нь сунгасан гарын зарчимд нийцэж байгаа эсэхийг тодорхойлохын тулд ЭЗХАХБ-ын ҮШ-ийн Удирдамжид “уламжлалт ажил гүйлгээний аргууд” болон “ажил гүйлгээний ашгийн аргууд” зэрэг ҮШ-ийн аргуудыг тодорхойлсон байна.</p> <p>Уламжлалт ажил гүйлгээний аргуудад дараах хамаарна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Харьцуулагдах бие даасан үнийн арга;</li> <li>• Дамжуулан борлуулах үнийн арга;</li> <li>• Өртөг дээр нэмэх арга.</li> </ul> <p>Ажил гүйлгээний ашгийн аргуудад дараах хамаарна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ажил гүйлгээний цэвэр ашгийн арга;</li> <li>• Ажил гүйлгээний ашиг хуваах арга.</li> </ul> <p>ҮШ-ийн аль нэг аргыг нөгөө аргаас нь илүү гэж үзэхгүй бөгөөд тухайн нөхцөл байдлаас хамаарч хамгийн тохиромжтой гэж үзсэн аргыг ашиглана. ҮШ-ийн шинжилгээний явцад харьцуулагдах ажил гүйлгээтэй холбоотой мэдээллийн олдоц, чанар болон ажил гүйлгээнүүдийн харьцуулагдах түвшинг харгалзан үзэж хамгийн тохиромжтой аргыг сонгоно.</p> <p>Монгол улсын ҮШ-ийн хууль тогтоомжид ЭЗХАХБ-ын ҮШ-ийн Удирдамжид нийцүүлэн дээр дурьдсан аргуудыг тусгасан байна. Татвар төлөгчид нь эдгээр аргуудаас дангаар нь болон хослуулан хэрэглэх боломжтой байна. Тухайн нэг ажил гүйлгээнд хэрэглэх аргыг тус бүрийн давуу болон сул талуудыг харьцуулах замаар сонгоно.</p> <p>Ерөнхий ҮШ-ийн зарчимд нийцүүлэн бусад аргыг хэрэглэхийг хуульд зөвшөөрсөн. Үүнд хөрөнгийн үнэлгээний аргууд, зах зээлд суурилсан арга, өртөгт суурилсан арга, эсхүл орлогод суурилсан арга хамаарна. Уул уурхайн бүтээгдэхүүний хувьд харьцуулагдах бие даасан үнийн аргыг хэрэглэхэд харьцуулагдах ажил гүйлгээ олдохгүй тохиолдолд Засгийн Газрын удирдамжид нийцүүлэн зарласан үнийн эх сурвалжид үндэслэж болно гэж заасан байна.</p>
<p><b>Мэдээллийн эх сурвалж</b></p>	<p>ЭЗХАХБ-ын ҮШ-ийн Удирдамжид харьцуулагдах ажил гүйлгээний талаар боломжит мэдээллийн эх сурвалжийг заасан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• олон нийтэд ил тод байгаа мэдээлэл;</li> <li>• арилжааны мэдээллийн сан;</li> <li>• дотоод эх сурвалжийн мэдээллүүд (хэрэв байгаа бол дотоод харьцуулалт хийх ажил гүйлгээ);</li> <li>• Бусад.</li> </ul> <p>Монгол улсын ҮШ-ийн хууль тогтоомжид зааснаар хэрэв татвар төлөгч нь харьцуулалтын тохируулга хийсэн тохиолдолд мэдээллийн эх үүсвэрийг холбогдох баримтуудын хамт ҮШ-ийн тайланд тусгах шаардлагатай байна.</p>



ҮШ-ийн үзэл баримтлал	Тайлбар																									
<p><b>ҮШ-ийн тохируулга</b></p>	<p>Ажил гүйлгээний бодит нөхцөл байдал нь харилцан хамааралтай этгээдүүд хооронд байгуулсан гэрээний нөхцөлүүдээс зөрүүтэй тохиолдолд татварын алба нь ҮШ-ийн шинжилгээний үр дүнд үндэслэн ҮШ-ийн тохируулгыг хийх эрхтэй байна.</p> <p>Мөн түүнчлэн, хэрэв татвар төлөгч нь ҮШ-ийн тайланг гаргаагүй, эсхүл татварын суурийг бууруулсан бол татварын алба ҮШ-ийн үндсэн тохируулгыг хийж татварыг нөхөн ногдуулна. Аж ахуйн нэгжийн орлогын татвар болон хувь хүний орлогын татварын зорилгоор үндсэн тохируулгын үр дүнд үүссэн зөрүүг ногдол ашиг гэж үзэн татвар ногдуулах бөгөөд үүнийг хоёрдогч тохируулга гэнэ.</p> <p>Хэрэв татвар төлөгч нь харьцуулалтын тохируулга хийсэн тохиолдолд уг тохируулгыг мэдээллийн эх үүсвэр болон бусад баримтаар нотлох шаардлагатай байна.</p> <p>ҮШ-ийн тохируулгын үр дүнд бий болсон татварын давхардлын асуудлыг дараах байдлаар шийдвэрлэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Монгол улсын татварын алба эсхүл гадаад улсын татварын албаны зүгээс ҮШ-ийн тохируулга хийсний улмаас татварын давхардал үүссэн тохиолдолд татварын алба нь Монгол улсын бусад улстай байгуулсан олон улсын татварын хэлэлцээрт нийцүүлэн татварын харилцан тохирох журмыг баримтална.</li> <li>• Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу татварын албаны зүгээс ҮШ-ийн тохируулга хийж татварыг нөхөн ногдуулсны улмаас Монгол улсад байрладаг татвар төлөгчид татварын давхардал бий болсон бол татварын алба нь уг давхардлыг арилгахын тулд холбогдох тохируулгыг хийж болно.</li> <li>• Бусад бүх тохиолдолд татварын алба татварын суурийг бууруулах аливаа тохируулгыг хийхгүй байна.</li> </ul>																									
<p><b>ҮШ-ийн тайлагнал</b></p>	<p>Хуульд заасан нөхцөлийг хангасан татвар төлөгчид нь дараах ҮШ-ийн тайлангуудыг бэлтгэж татварын албанд хүргүүлнэ.</p> <table border="1" data-bbox="336 1249 1519 1809"> <thead> <tr> <th data-bbox="336 1249 384 1317">N</th> <th data-bbox="384 1249 587 1317">ҮШ-ийн тайлангийн нэр</th> <th data-bbox="587 1249 906 1317">Агуулга</th> <th data-bbox="906 1249 1299 1317">Хэн тайлагнах</th> <th data-bbox="1299 1249 1519 1317">Хэзээ тайлагнах</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="336 1317 384 1413">1</td> <td data-bbox="384 1317 587 1413">ҮШ-ийн ажил гүйлгээний жилийн тайлан</td> <td data-bbox="587 1317 906 1413">Харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээний мэдээлэл</td> <td data-bbox="906 1317 1299 1413">Харилцан хамааралтай этгээдтэй ажил гүйлгээ хийсэн бүх татвар төлөгч</td> <td data-bbox="1299 1317 1519 1413">Дараа жилийн 2 сарын 10-ны дотор</td> </tr> <tr> <td data-bbox="336 1413 384 1525">2</td> <td data-bbox="384 1413 587 1525">Дотоод ҮШ-ийн тайлан</td> <td data-bbox="587 1413 906 1525">Монголд дахь аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл</td> <td data-bbox="906 1413 1299 1525">Өмнөх татварын жилд 6 тэрбум төгрөг (ойролцоогоор 2 сая ам. доллар) болон түүнээс дээш борлуулалтын орлого олсон татвар төлөгч, групп компани; гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж</td> <td data-bbox="1299 1413 1519 1525">Дараа жилийн 2 сарын 10-ны дотор</td> </tr> <tr> <td data-bbox="336 1525 384 1621">3</td> <td data-bbox="384 1525 587 1621">Ерөнхий ҮШ-ийн тайлан</td> <td data-bbox="587 1525 906 1621">Группын бизнес болон үйл ажиллагааны талаарх товч мэдээлэл</td> <td data-bbox="906 1525 1299 1621"></td> <td data-bbox="1299 1525 1519 1621"></td> </tr> <tr> <td data-bbox="336 1621 384 1809">4</td> <td data-bbox="384 1621 587 1809">Улс бүрээр тайлан</td> <td data-bbox="587 1621 906 1809">Улс бүрээрх санхүүгийн болон татварын мэдээлэл</td> <td data-bbox="906 1621 1299 1809">Нэгтгэсэн санхүүгийн тайлангаар 1.7 их наяд төгрөг (ойролцоогоор 600 сая ам. доллар) болон түүнээс дээш борлуулалтын орлоготой үндэстэн дамнасан группын Монгол улсад байрладаг толгой компани эсхүл бусад томилогдсон этгээд</td> <td data-bbox="1299 1621 1519 1809">Группын санхүүгийн жилийн сүүлийн өдрөөс хойш 12 сарын дотор</td> </tr> </tbody> </table>	N	ҮШ-ийн тайлангийн нэр	Агуулга	Хэн тайлагнах	Хэзээ тайлагнах	1	ҮШ-ийн ажил гүйлгээний жилийн тайлан	Харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээний мэдээлэл	Харилцан хамааралтай этгээдтэй ажил гүйлгээ хийсэн бүх татвар төлөгч	Дараа жилийн 2 сарын 10-ны дотор	2	Дотоод ҮШ-ийн тайлан	Монголд дахь аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл	Өмнөх татварын жилд 6 тэрбум төгрөг (ойролцоогоор 2 сая ам. доллар) болон түүнээс дээш борлуулалтын орлого олсон татвар төлөгч, групп компани; гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж	Дараа жилийн 2 сарын 10-ны дотор	3	Ерөнхий ҮШ-ийн тайлан	Группын бизнес болон үйл ажиллагааны талаарх товч мэдээлэл			4	Улс бүрээр тайлан	Улс бүрээрх санхүүгийн болон татварын мэдээлэл	Нэгтгэсэн санхүүгийн тайлангаар 1.7 их наяд төгрөг (ойролцоогоор 600 сая ам. доллар) болон түүнээс дээш борлуулалтын орлоготой үндэстэн дамнасан группын Монгол улсад байрладаг толгой компани эсхүл бусад томилогдсон этгээд	Группын санхүүгийн жилийн сүүлийн өдрөөс хойш 12 сарын дотор
N	ҮШ-ийн тайлангийн нэр	Агуулга	Хэн тайлагнах	Хэзээ тайлагнах																						
1	ҮШ-ийн ажил гүйлгээний жилийн тайлан	Харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээний мэдээлэл	Харилцан хамааралтай этгээдтэй ажил гүйлгээ хийсэн бүх татвар төлөгч	Дараа жилийн 2 сарын 10-ны дотор																						
2	Дотоод ҮШ-ийн тайлан	Монголд дахь аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл	Өмнөх татварын жилд 6 тэрбум төгрөг (ойролцоогоор 2 сая ам. доллар) болон түүнээс дээш борлуулалтын орлого олсон татвар төлөгч, групп компани; гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж	Дараа жилийн 2 сарын 10-ны дотор																						
3	Ерөнхий ҮШ-ийн тайлан	Группын бизнес болон үйл ажиллагааны талаарх товч мэдээлэл																								
4	Улс бүрээр тайлан	Улс бүрээрх санхүүгийн болон татварын мэдээлэл	Нэгтгэсэн санхүүгийн тайлангаар 1.7 их наяд төгрөг (ойролцоогоор 600 сая ам. доллар) болон түүнээс дээш борлуулалтын орлоготой үндэстэн дамнасан группын Монгол улсад байрладаг толгой компани эсхүл бусад томилогдсон этгээд	Группын санхүүгийн жилийн сүүлийн өдрөөс хойш 12 сарын дотор																						
<p><b>ҮШ-ийн тайлангуудыг тушаагаагүй тохиолдолд хүлээх хариуцлага</b></p>	<p>ҮШ-ийн тайлангуудыг хугацаанд нь гаргаж татварын албанд тушаагаагүй тохиолдолд дараах торгуулийг ногдуулахаар хуульд заасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>ҮШ-ийн ажил гүйлгээний жилийн тайлангийн</b> хувьд, харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн 2 хувь;</li> <li>• <b>Дотоод болон ерөнхий үнэ шилжилтийн тайлангийн</b> хувьд, харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн 3 хувь;</li> <li>• <b>Улс бүрээр тайлангийн</b> хувьд, харилцан хамааралтай этгээд хооронд хийгдсэн ажил гүйлгээний нийт дүнгийн 4 хувь.</li> </ul>																									

ҮШ-ийн үзэл баримтлал	Тайлбар
<p><b>Бусад асуудал</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Шинэчилсэн зохицуулалтын хүрээнд ҮШ-ийн тайлагналын нарийвчилсан заавар, журам нэмэгдэж гарахаар хүлээгдэж байна.</li> <li>• Урьдчилсан үнийн хэлэлцээртэй холбоотой зохицуулалт одоогийн байдлаар тусгагдаагүй байна.</li> <li>• Монгол улсад татварын хөөн хэлэлцэх хугацаа 4 жил байна. ҮШ-ийн тохируулгатай холбоотойгоор Монгол улсын татварын алба гадаад улсын татварын албанаас мэдээлэл гаргуулах хүсэлт илгээсэн тохиолдолд хүсэлтийг гаргасан өдрөөс хариу хүлээн авсан өдөр хүртэлх хугацаанд татварын хөөн хэлэлцэх хугацааг тасалдсан тооцно.</li> <li>• Үл мэдээлэгч улс буюу Монгол улстай татварын зорилгоор мэдээлэл солилцдоггүй болон эрсдэлтэй татварын тогтолцоотой улс, бүс нутагт байрлах этгээдтэй хяналтад байгаа ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн тохиолдолд татварын албаны зүгээс нөхөн ногдуулалтын арга хэмжээ авах боломжтой байна. Үл мэдээлэгч улс, бүс нутгийн жагсаалтыг жил бүрийн 1-р сарын 10-ны өдрийн дотор татварын алба өөрийн албан ёсны цахимд хуудаст мэдээлэх юм байна.</li> </ul>

## Танд PwC хэрхэн туслах вэ

### Тайлагнал, хууль даган мөрдөх:

- Бүх төрлийн ажил гүйлгээний ҮШ-ийн баримтжуулалт, тайланг дотоодын хууль тогтоомжийн шаардлагын дагуу бэлтгэх, өөрчлөлт оруулах
- Үнэ, ашиг, хүү, эрхийн шимтгэлийн түвшинд жишиг үнийн судалгаа хийх
- ҮШ-ийн ажил гүйлгээний жилийн тайлан, дотоод ҮШ-ийн тайлан, Ерөнхий ҮШ-ийн тайлан болон Улс бүрээр тайлан бэлтгэх, туслалцаа үзүүлэх

### Өдөр тутам туслалцаа үзүүлэх:

- ҮШ-ийн эрсдлийг тодорхойлох
- ҮШ-ийн бодлого, журам боловсруулах, байгууллагын үнэ шилжилтийн асуудал хариуцсан ажилтанг сургах
- ҮШ-ийн асуудлаар шуурхай зөвлөгөө өгөх

### Төлөвлөлт ба өөрчлөлт:

- Бизнесийн үйл ажиллагааны бүтцийг татварын үр ашигтай байдалд нийцүүлэх
- Үнэ шилжилтийн бодлогыг бизнесийн загвартай уялдуулах
- Төлөөний газрын ашиг, орлогыг зохистой хуваарилах

### Байр сууриа хамгаалах ба маргаан шийдвэрлэх:

- Стратеги, аргумент боловсруулах
- Татварын хяналт шалгалтын үед туслалцаа үзүүлэх
- Татварын маргааны үед туслалцаа үзүүлэх
- Харилцан тохирох журмын хүрээнд туслалцаа үзүүлэх